

**ХОТ СУУРИН ГАЗРЫН АГААРЫН БОХИРДЛЫН ЭРҮҮЛ МЭНДЭД ҮЗҮҮЛЭХ  
НӨЛӨӨЛЛИЙН СУДАЛГАА”-НЫ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
СУДАЛГААНЫ АЖЛЫН ЖАГСААЛТ**

<b>Дугаар</b>	<b>Судалгааны чиглэл</b>
БС-12/01	Агаарт агуулагдах бохирдуулагч (Хүхэрлэг хий, азотын давхар исэл, хар тугалга, хүнцэл, кадми, диоксин, фуран) бодисын агууламж, түүний хүний эрүүл мэндэд үзүүлж буй нөлөөллийг үнэлэх
БС-12/02	Агаар дах тоос, тоосонцрын бохирдлын эрүүл мэндэд үзүүлж буй нөлөөлөл, сонгогдсон хот суурингийн хүн амын тэр ялангуяа хүүхэд, жирэмсэн эхчүүд, өндөр настан, амьсгал, зүрх судасны архаг өвчтэй хүмүүсийн өвөрмөц бус дархлалын тогтолцоонд үзүүлэх нөлөөллийг тогтоох
БС-12/03	Агаарын бохирдлын улмаас эрүүл мэндийн салбарт учруулж буй эдийн засгийн ачааллыг үнэлэх
БС-12/04	Агаарын бохирдлын амьгүй төрөлт, бага жинтэй төрөлт, төрөлхийн гажигт үзүүлж буй нөлөөлөл, сайжруулсан зуухны эрүүл мэндийн үр нөлөөг судлах

Зөвлөхийн жагсаалтад орох саналыг **2012 оны 1 дүгээр сарын 20-ний өдрийн 17 цагт** бичгээр ирүүлэх ба дараахь шаардлагыг хангасан байна. Үүнд:

- 1. Судалгааны төсөлт ажлыг хэрэгжүүлж байсан туршлагын талаарх танилцуулга /төсөлт ажлын үр дүн, гүйцэтгэлийг баталгаажуулсан баримтыг хавсаргах/**
- 2. Судлаачдын чадварыг илэрхийлсэн танилцуулга /нотлох бичиг баримтыг хавсаргах/**

Гүйцэтгэгчийг чанарын болон чадварын үнэлгээний аргыг ашиглан 2 үе шаттайгаар шалгаруулна.

*1-р үе шат:* Дэлгэрэнгүй жагсаалтад ирүүлсэн саналыг үнэлж, хураангуй жагсаалт үүсгэх ба жагсаалтад багтсан хуулийн этгээд болон хувь хүнд тендерт оролцох саналын урилгыг хүргүүлнэ.

*2-р үе шат:* Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгох журмын дагуу шалгаруулна.

**Санал хүлээн авах хаяг:**

Эрүүл мэндийн яам  
Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар  
Улаанбаатар хот 14210,  
Олимпийн гудамж -2,  
Засгийн газрын VIII байр, 303 тоот өрөө  
Утас: 263892, 88016621  
Цахим шуудан: dnyam\_21@yahoo.com